



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/117

Мандалговь

Г

Г

Гэрээ байгуулах тухай


Монгол улсын Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоол, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. Японы засгийн газрын Өвсний үндэс хөтөлбөрийн хөрөнгөөр санхүүжигдэх “Адаацаг сумын сургуулийн нэгдсэн гадна дулааны шугам”-ын ажлын санхүүгийн гүйцэтгэлд хөндлөнгийн хяналт /аудит/ тавих ажлын гүйцэтгэгчээр “Саруул баян уул – Аудит” ХХК-ийг сонгон 2,100,000 /хоёр сая нэг зуун мянган/ төгрөгөөр шууд гэрээ байгуулсугай.

Хоёр. Санхүүгийн гүйцэтгэлд хөндлөнгийн хяналт тавих ажлыг чанартай хийж гүйцэтгэхийг “Саруул баян уул - Аудит” ХХК –ний захирал /Б.Шатар/-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу гүйцэтгэж буй ажилд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /Н.Эрдэнэ-Очир/-т үүрэг болгосугай.

ДАРГА



О.ЧУЛУУНБАТ

0200345